# Бүгд Найрамдах Монгол Ард Улсын
# Сайд нарын Зөвлөлийн
# ТОГТООЛ

1978 оны 9 дүгээр сарын II-ний өдөр

Дугаар 294

Улаанбаатар хот

**Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны зохион байгуулалт, орон тоог батлах тухай**

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ нь:

I.Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны зохион байгуулалтыг дор дурдсанаар баталсугай:

а/зохион зааварлах хэлтэс;
б/санхүүгийн хэлтэс;
в/төлөвлөгөөний комисс;
г/статистикийн товчоо;
д/ардын боловсролын хэлтэс;
е/хөдөлмөр, нийгэм хангамжийн хэлтэс /гадаадын харьяат иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцах тасагтай/;
ж/орон сууц,нийтийн үйлчилгээний хэлтэс;
з/цэрэг, иргэний хамгаалалтын хэлтэс;
и/их барилгын хэлтэс;
к/иргэний гэр бүлийн байдлыг бүртгэх хэлтэс;
л/соёлын хэлтэс;
м/эрүүлийг хамгаалах газар;
н/хөдөө аж ахуйг удирдах газар;
о/аж ахуйн хэлтэс.

2.Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны орон тоог I дүгээр хавсралт ёсоор 102 нэгжээр баталсугай.

3.Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга, орлогч, хариуцлагатай нарийн бичгийн дарга нарын ажлын хуваарийг 2 дугаар хавсралт ёсоор батлаcугай.

4.Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны харьяа барилга-архитектурын газрын одоогийн зохион байгуулалтыг өөрчлөн Улаанбаатар хотын архитектур-төлөвлөлтийн газар болгон аж ахуйн тооцооны үндсэн дээр ажиллуулахыг Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаа /н.МӨНХЖАРГАЛ/-д зөвшөөрсүгэй.

5.Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дуудлагын автомашин хэрэглэх эрхийг нэгээр нэмэгдүүлсүгэй.

6.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Сайд нарын Зөвлөлийн доор дурдсан зарим тогтоолын заалтыг хүчингүй болсонд тооцсугай:

а/"Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны зохион байгуулалт, орон тоог батлах тухай" Сайд нарын Зөвлөлийн 1975 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 104 дүгээр тогтоолын I дүгээр зүйл, 2 дугаар зүйлээр баталсан I дүгээр хавсралт, 4 дүгээр зүйлийн "а" заалт;

б/"Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргааны зохион байгуулалт, орон тоонд зарим өөрчлөлт оруулах тухай" Сайд нарын Зөвлөлийн 1976 оны II дүгээр сарын I2-ны өдрийн 387 дугаар тогтоолын I, 5 дугаар зүйл;

в/"Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаанд хөдөө аж ахуйг удирдах газар байгуулах тухай" Сайд нарын Зөвлөлийн 1977 оны 6 дугаар сарын I7-ны өдрийн I83 дугаар тогтоолын I, 3 дугаар зүйл;

г/"Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаанд хэлтэс байгуулах тухай" Сайд нарын Зөвлөлийн 1976 оны 6 дугаар сарын I0-ны өдрийн I28 дугаар тогтоолын I дүгээр зүйл.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга — Ж.БАТМӨНХ

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн Хэрэг эрхлэх газрын дарга — Б.БАДАРЧ

Хуулбар үнэн: Тогтоол ангийн эрхлэгч /Ц.ЦЭНДЭЭХҮҮ/

Сайд нарын Зөвлөлийн 1978 оны 294 дүгээр тогтоолын I дүгээр хавсралт

# УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ОРОН ТОО

| № | Албан тушаал | Орон тоо |
|---|---|---|
| I. | Дарга | I |
| 2. | Нэгдүгээр орлогч дарга бөгөөд төлөвлөгөөний комиссын дарга | I |
| 3. | Орлогч дарга бөгөөд их барилгын хэлтсийн дарга | I |
| 4. | Орлогч дарга бөгөөд хот тохижуулах газрын дарга | I |
| 5. | Орлогч дарга | 2 |
| 6. | Хариуцлагатай нарийн бичгийн дарга | I |
| 7. | Газрын дарга | 2 |
| 8. | Хэлтсийн дарга | 7 |
| 9. | Хэлтсийн дарга бөгөөд гэрлэх ёслолын ордны дарга | I |
| I0. | Товчооны дарга | I |
| II. | Төлөвлөгөөний комиссын орлогч | I |
| I2. | Газар, хэлтсийн орлогч | 3 |
| I3. | Хэлтсийн доторхи тасгийн дарга | I |
| I4. | Хотын ерөнхий архитектор | I |
| I5. | Ахмадын зөвлөлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга | I |
| I6. | Ерөнхий нягтлан бодогч | I |
| I7. | Боловсон хүчин | I |
| I8. | Ахлах мэргэжилтэн, ахлах байцаагч | 7 |
| I9 | Мэргэжилтэн, байцаагч, зааварлагч | 47 |
| 20. | Хуулийн зөвлөх | I |
| 2I. | Цэрэг, иргэний хамгаалалтын туслах | 3 |
| 22. | Агрономч, зоотехникч | 2 |
| 23. | Байцаагч-нягтлан бодогч | 4 |
| 24. | Даргын нарийн бичгийн дарга | I |
| 25. | Ой, ангийн байцаагч | I |
| 26. | Оператор-бичээч | I |
| 27. | Архивын эрхлэгч | I |
| 28. | Аж ахуйн хэлтсийн дарга | I |
| 29. | Аж ахуйн комендант | I |
| 30. | Бичиг хэргийн эрхлэгч | I |
| 3I. | Ахлах бичээч | I |
| 32. | Бичээч | 3 |
| | ДҮН | I02 |

Сайд нарын Зөвлөлийн 1978 оны 294
дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ДАРГА,ОРЛОГЧ,ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
НАРЫН АЖЛЫН ХУВААРЬ

I.Дарга

а/хотын бүх ажлыг удирдах, зохион байгуулах ерөнхий асуудал;

б/боловсон хүчин, гадаад харилцааны асуудал;

в/хотын санхүү, статистик, банкны асуудал;

г/цэрэг, иргэний хамгаалалт, улсыг батлан хамгаалахад туслах нийгэмлэгийн асуудал;

д/ардын хянан шалгах, шүүх, цагдан сэргийлэхийн асуудал.

2.Нэгдүгээр орлогч дарга бөгөөд төлөвлөгөөний комиссын дарга

а/хотын төлөвлөгөөний асуудал;

б/хотын тээвэр, худалдаа, бэлтгэл, нийтийн хоолны асуудал;

в/хөдөө аж ахуйн асуудал;

г/социалист уралдаан, шинэ санаачилга, тэргүүн туршлагын асуудал;

д/байгаль орчныг хамгаалах асуудал;

е/зах зээлийн худалдаа, үйлчилгээний асуудал.

3.Нийгэм, соёл эрхэлсэн орлогч дарга

а/ардын боловсрол, соёл, биеийн тамир-спортын асуудал;

б/эмнэлэг,ариун цэвэр, эрүүл ахуйн асуудал;

в/гадаадын мэргэжилтнээс дагалдан суралцах, мэргэжил дээшлүүлэх асуудал;

г/хөдөлмөрчид,насанд хүрээгүй хүмүүсийн дунд зохиох соёл хүмүүжлийн ажил.

4.Орон сууц, нийтийн үйлчилгээ эрхэлсэн орлогч дарга

а/орон сууцны хуваарилалт, ашиглалт, дулаан, цахилгаан, орон сууц, гэрийн хорооллын усан хангамжийн асуудал;

б/ахуйн ба гадаадын мэргэжилтний үйлчилгээний асуудал;

в/телефон, радио ашиглалтын асуудал.

5.Барилга эрхэлсэн орлогч дарга бөгөөд их барилгын хэлтсийн дарга

а/хотын архитектур, ерөнхий төлөвлөгөөний асуудал;

б/хөрөнгө оруулалт,барилга-угсралт, засварын асуудал;

в/материал-техникийн хангамжийн асуудал;

г/усны аж ахуй, зам, талбай, далан сувагийн барилга байгууламжийн асуудал;

д/хотын газар эдэлбэрийг сайжруулах, барилга байгууламжийн газар олгохтод тавих барилгын байцаан шалгах ба захиалагчийн хяналтын асуудал.

6.Орлогч дарга бөгөөд хот тохижуулах газрын дарга

а/хот тохижуулалт, ногоорулалт, цэцэрлэгжүүлэлтийн асуудал;

б/хотын цэвэрлэгээ,хог тээвэрлэлт,боловсруулалтын асуудал;

в/хотын гэрэлтүүлэг, реклам чимэглэлийн асуудал;
г/иргэдийг үйлчлэх товчооны асуудал;
д/хотын зуслангийн асуудал.

7.Хариуцлагатай нарийн бичгийн дарга

а/хот, район, хороодын ардын депутатуудын хурал, тэдгээрийн гүйцэтгэх захиргааны асуудал;

б/ардын хурлын сонгууль, чуулган, депутат, байнгын комиссын асуудал;

в/гүйцэтгэлийн хяналт шалгалтын асуудал;

г/хөдөлмөр, нийгэм хангамжийн асуудал;

д/хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дотоод аппарат, аж ахуй, санхүүгийн асуудал;

е/иргэний гэр бүлийн асуудал;

ж/нийгмийн хэв журам сахиулах асуудал;

з/архивын асуудал;

и/хөдөлмөрчдийн эрэлт хүсэлт, санал, гомдол, иргэдийн шилжин суух, түр явах журмыг дагаж мөрдүүлэх, паспортжуулах, засаг захиргааны ажлын мэдээ тайлангийн асуудал.

_______оОо_______